

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2023 оны жилийн эцсийн байдлаар/**

2023 оны 12 дугаар сарын 27-ны өдөр

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Монгол Улсын Их Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 2 зорилгын 21 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн unelgee.gov.mn/ цахим системд байршуулсан 2 зорилтын 21 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- МУХТ 2.4.Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.
- МУХТ 4.1.Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

Хяналтад авагдсан 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба биелэлт 69.52 хувьтай /хүснэгт №1/ үнэлэгдлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн
2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний үнэлгээний товчоо
/2023 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт №1

Хэрэгжилт гаргах нийт төсөл, арга хэмжээний тоо		21
Үр дүнтэй	100%	-
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	<u>10</u>
	70%	<u>5</u>
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	<u>3</u>
	30%	<u>2</u>
Үр дүнгүй	0%	<u>1</u>
Хугацаа болоогүй	Хугацаа болоогүй	-
Хэрэгжилтийн дундаж		69.52%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн
2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт
/2023 оны 10 дугаар сарын байдлаар/

Хүснэгт 2

Зорилго	Арга хэмжээний тоо	Үнэлгээ (хувь)						Хэрэгжилт (хувь)
		100	90	70	50	30	0	
2.4. Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.	19		9	5	3	1	1	70.52%

4.1. Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	2		1			1		60.0%
Нийт дүн	21		10	5	3	2	1	69.52%

2023 оны жилийн эцсийн байдлаар “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 1 арга хэмжээ байна. Үүнд:

1. Геологийн 1:25000-ны масштабын зураглал бүхий газар нутгийн хэмжээ

2023 оны 10 дугаар сарын байдлаар “ Эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 2 арга хэмжээ байна. Үүнд:

1. Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх 30 оноо.
2. Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх (Конвейерийн систем нэвтрүүлэх ажлын явц, хувиар) 30

Дөрөв. Дүгнэлт

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны жилийн эцсийн байдлаар 69.52 хувьтай үнэлэгдэв.
2. 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд нь ЗГҮАХ-т батлагдсан арга хэмжээнүүдээс хэрэгжих хугацаа хоцролттой, зөрүүтэй цаашид Улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа урт дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хэрэгжих хугацааг уялдуулах,
3. Зарим арга хэмжээг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийг хэмжээг тайлагнахгүй тодорхой бус, зарим арга хэмжээ нийт зарцуулах хөрөнгийг бичиж тайлагнаж байна.
4. Хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй арга хэмжээнүүд нь тухайн жилд зарцуулсан хөрөнгө, гүйцэтгэл, санхүүжилт тодорхойгүй, хийсэн ажил авч хэрэгжүүлсэн ажлуудын цаг хугацаа тодорхой бус байгаа нь биелэлтийн түвшинг үнэлэх, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулахад хүндрэл үүсгэж байна.

Тав. Санал, зөвлөмж

1. Улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа урт дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хэрэгжих хугацааг

- уялдуулах,тайлант хугацаандаа хэрэгжихүйц, биелэж болохуйцаар төлөвлөхөд анхаарах
2. Хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилт хангалтгүй болон тасарсан арга хэмжээний талаар холбогдох арга хэмжээг авах,
 3. Хэрэгжилт хангалтгүй “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй арга хэмжээг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх талаар хариуцсан нэгжүүд онцгой анхаарч тусгайлан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах, хэрэгжих боломжгүй бол бодлогын баримт бичгээс хасуулах санал бэлтгэх,
 4. Төсөл, арга хэмжээг хариуцсан нэгжүүд нь төсөвт өртөг, гүйцэтгэл, санхүүжилтийн хэмжээг нарийн тодорхой тайлагнах,
 5. Нэгжүүд Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, арга хэмжээ нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, хэрэгжих хугацаа болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, зорилго, зорилт, хүрэх түвшин хэрэгжих хугацаатай хэрхэн уялдаж байгааг анхаарах,
 6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох нэгж, албан тушаалтан хариуцан зохион байгуулах,

Хянасан:

ХШҮДАГ-ын дарга

Т.Баасанпүрэв

ХШҮ хийж, танилцуулга боловсруулсан:

ХШҮДАГ-ын ЦБМТХ-ийн шинжээч

Д.Батнайрамдал

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ
/2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР/

	№	Зорилт /бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт		2023 онд шаардлагатай хөрөнгө		Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
					Суурь түвшин /2021	Зорилтот түвшин /2023/	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Эх үүсвэр		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Зорилго 2.4. Аж үйлдвэржилтийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд уул уурхайн түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлж, үнэ цэнийг нэмэгдүүлнэ.										
1	2.4.1	МУХТЖҮЧ- 4.2.11, ЗГҮАХ- 3.2.7, 3.2.8	Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг түүхий эдийг боловсруулах хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлэх	Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлын явц, хувиар	50	90	200,000.0	Гадаадын зээл, тусламж	Технологийн бус барилга байгууламжийн ажил /ЕРС-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 98.6%-тай байна. Үйлдвэрийн Анхдагч технологийн байгууламж /ЕРС-2/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 0,79%-тай байна. Үйлдвэрийн цахилгаан станц /ЕРС-3/ багцын инженерчлэлийн ажил дууссан, ерөнхий гүйцэтгэл 1,32%-тай байна. Лицензтэй технологийн байгууламж /ЕРС-4/ багцын инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулж барилга угсралтын гэрээг 2023.09.29-ний өдөр МГТБҮ ТӨХХК болон ерөнхий гүйцэтгэгч БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructures Limited” компани хооронд байгуулсан. Төслийн нийт хэрэгжилт 11,0%-тай.	70

2				Газрын тос дамжуулах хоолойн бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	10	90	330,000.0	Гадаадын хөрөнгө оруулалт	Төслийн ерөнхий гүйцэтгэл: Инженерчлэл-70,0%, Худалдан авалт-35,5%, Барилга угсралт- 38,6%-ийн гүйцэтгэлтэй байна. Байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -100%, геотехникийн судалгааны ажил -95%, Техникийн зураг төслийн ажил - 90%, БОННУ хийх ажил- 100%, төслийн талбайд нийт 19220 ширхэг буюу 230 км хоолойг хүлээн авч, үүнээс 15250 ширхэг буюу 183 км хоолойг дамжуулах хоолойн трассын дагуу цувьж байрлуулан 167км хоолойг гагнаж 155км хоолойд сорил хийсэн дүнтэй байна. Мөн Үндсэн түр кемп 100%, • Толгой станцын түр кемп 77%, • Халаах, өргөх станц-1 түр кемп 79%, • Халаах, өргөх станц-2 түр кемп 100% • Халаах, өргөх станц-3 түр кемп 78% •Халаах, өргөх станц-4 түр кемп 93%-ийн тус тус гүйцэтгэлтэй.	90
3				"Алтанширээт аж үйлдвэрийн парк"-ийн барилгын явц, хувиар	-	75	912,000.0	Дотоодын хөрөнгө оруулалт	"Инфинити спэйс" ХХК ("Болдтөмөр Ерөө гол" ХХК) өөрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт нийт 140 га талбайд "Алтанширээт үйдвэрлэл, технологийн парк" байгуулах төслийг 2019-2026 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Цогцолборын хэмжээнд нийт 420 орчим сая ам.долларын	90

									хөрөнгө оруулалтаар жилд 500 мянган тонн хүчин чадалтай ширэмний үйлдвэр бүхий 5 үйлдвэр байгуулагдах ба эхний 4 үйлдвэр нь ширэмний үйлдвэрээ түүхий эдээр хангах зорилготой. Төслийн явц 2019-2022 онд хийгдсэн ажил: • 110/10 кВт-ын 9.4 км цахилгаан дамжуулах агаарын шугам • 6.3 МВт-ын цахилгааны дэд станц • 12 км төмөр зам • Усан хангамжийн нэгдсэн сүлжээ, Паркийн усан хангамжийг шийдэх зорилгоор Бор хөөвөр болон Долоодын говиос гүний ус дамжуулах 103 км урттай шугамын трассын зураглал хийсэн. • Түүхий эд болон бүтээгдэхүүнийг тээвэрлэх төмөр зам, авто замын бүтээн байгуулалтуудыг тус тус гүйцэтгэсэн. • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. • Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг барьж байгуулсан. 2023 онд хийгдсэн ажил: • Коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн үйлдвэр, ширэмний үйлдвэрийн ТЭЗҮ-ийг тус тус боловсруулж “Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөл"-өөр хэлэлцүүлэн дэмжигдсэн. • Мөн үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах бэлтгэл ажлын хүрээнд технологийн түвшний үнэлгээ, паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдсэн. • Коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн үйлдвэр, ширэмний үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн Хүнд үйлдвэрийн ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. • ҮТП байгуулах газрыг Дорноговь аймгийн ИТХ-ын 2023.03.23-ны өдрийн тогтоолоор орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. • Паркад байгуулах төмрийн хүдэр нойтон аргаар баяжуулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэрийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2023 оны 07 сард Байгаль орчин, аялал жуулчлалын яам хэлэлцэж, баталсан. • Засгийн газрын 2023.07.05-ны өдрийн 257 дугаар тогтоолоор үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон. • НБҮ-ийн барилгын ажил, тоног төхөөрөмж суурьлуулах	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									ажлыг 2023.04 сараас үргэлжлүүлэн энэ онд ашиглалтад оруулахад бэлэн болсон. Гүйцэтгэл-100 % • Коксын үйлдвэрийн газар, шороо, суурийн цутгалтын ажлыг хийж дуусгасан. Гүйцэтгэл 100 % 2023 онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлыг хүйтний улирал эхэлсэнтэй холбоотойгоор 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс зогсоосон ба 2024 оны 03 дугаар сараас ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.	
4			Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах барилгын явц, хувиар	-	45.4	656,177.5	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь 2023 оны бизнес төлөвлөгөөг “Эрдэнэс Монгол” ХХК-иар, худалдан авалтын төлөвлөгөөг Сангийн ямааар 2023 оны 4 дүгээр сард тус тус батлуулсан. Төслийн ажлын бэлтгэл хангах, судалгааны болон бусад ажлын хүрээнд дараах ажлуудыг 2023 онд гүйцэтгээд байна. Үүнд: -Төмөртэйн уурхайн нойтон баяжуулах үйлдвэр, хорголжийн үйлдвэрийн цахилгаан хангамжийн горимын тооцоог Диспетчерийн үндэсний төвөөр хийлгэж хүлээн авсан. -“Монгол ган цогцолбор I” төслийн 3D макет хийлгэх ажлын гүйцэтгэл 100 %. - Төслийн газар шорооны тэгшилгээний ажлыг 9-10 сард гүйцэтгэж нийт 417,477 м3 хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэсэн. - “Эрдэнэс Монгол” ХХК-иас “Монгол ган цогцолбор I” төслийн концепци, хүчин чадлыг өөрчлөн	70	

									1 сая тн бэлдэц, бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай “Ган үйлдвэрлэлийн цогцолбор” байгуулах төслийг хэрэгжүүлэх чиглэл өгсөн тул төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) хийлгэх ажлыг гүйцэтгэгч компанид мэдэгдэл хүргүүлж ажлыг зогсоосон. Одоогийн төмөрлөгийн үйлдвэрийн шинэчлэлийн хүрээнд: -“Мини шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төсөл хэрэгжүүлэх хүрээнд “Металлурги, дэвшилтэт технологийн судалгааны төв” болон “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу төслийн ТЭЗҮ-ийг боловсруулахад зориулж ШУТИС-ийн Механик тээврийн сургуулийн “Металлурги, дэвшилтэт технологийн судалгааны төв”-өөр шууд ангижруулсан төмрийн технологийн туршилтыг хийлгэж эцсийн тайланг хүлээн авсан. -Мини шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн төслийн хүрээнд жилд 100 мян.тн хүчин чадалтай “Шууд ангижруулсан төмрийн үйлдвэр”-ийн төслийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэс ҮТП” ХХК боловсруулж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2023.11.28-ны өдрийн 01/1011 дугаар албан бичгээр төслийн шинжээч томилж, ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг УУХҮ-ийн яаманд ирүүлсэн.	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

5				"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэл хийх барилгын ажлын явц, хувиар	69.4	100	86,467.0	Дотоодын хөрөнгө оруулалт	2020-2021 онд дэлхий нийтийг хамран дэгдсэн халдварт цар тахлын улмаас БНХАУ, ОХУ зэрэг дэлхийн улс орнууд хилээ хаах хүртэл арга хэмжээ авч, онцгой дэглэм тогтоосон, материалын үнийн өсөлт болон тээвэр ложистикийн хүндрэлтэй асуудал үүссэн, Орос-Украины дайны улмаас барууны орнууд ОХУ-ын эсрэг эдийн засгийн хориг тавьж, Европт эрчим хүчний хямрал нүүрлэсэн, инфляцыг дагаад үнийн хөөрөгдөл бий болсон зэрэг давагдашгүй хүчин зүйл, түүний сөрөг үр дагавар нь 2022, 2023 онд ч нөлөөлж буй нь "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хувьд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн саад, хүндрэл учруулсан байна. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 50%, Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%, Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эхний ээлжийн /ӨНХ-ийн хүдэр боловсруулах 4-р шинэ шугам, Хам баяжуулалтын 12 сая тн/жил хүчин чадалтай 5-р секцийг шинэчлэх/ төслүүд 100% хийгдсэн ба одоо Баяжуулах үйлдвэрт 4 төсөл хэрэгжиж байна. Засварын механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн төслийн	90
---	--	--	--	--	------	-----	----------	---------------------------	--	----

								нарийвчилсан ТЭЗҮ болон инженерийн зураг төслийг боловсруулж, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлж хүлээн авсан. Уг төслийн хүрээнд одоогийн цутгуурын үйлдвэрлэлийн Илчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл, Механик цехийн өргөтгөл шинэчлэл, шинэ Цутгуурын цех байгуулах ажил төлөвлөгөөний дагуу хийгдэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 37%-тай байна.	
								"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын Ил уурхай, Баяжуулах үйлдвэр, Засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэл хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл дунджаар 84%-тай байна.	
								(2023.12.26-ний өдрийн байдлаар)	
6			"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" барих ажлын явц, хувиар	-	100	133,663.0	Дотоодын хөрөнгө оруулалт	Паркийн тусгай зөвшөөрөл: "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн ТЭЗҮ, БОННУ, Ерөнхий төлөвлөгөө батлагдсан. ҮТП-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129-р тогтоолоор 5 жилийн хугацаатай олгосон боловч Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ батлагдсантай	50

									холбогдуулан хүчингүй болсон тул тус хуульд нийцүүлэн тусгай зөвшөөрөл авах бэлтгэл ажлыг хангаж байна. Паркийн газар: Засгийн газрын “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гуравласан гэрээг УУХҮ-ийн яам, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн засаг дарга хооронд 2022.10.25-ны өдөр байгуулж, тус гэрээний дагуу ҮТП-ийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн №000000019 дугаартай Газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр аваад байна. Үйлдвэрлэл, технологийн паркийн газрын эзэмших, ашиглах газрын хил заагийн эргэлтийн цэгийг тэмдэгжүүлж, солбилцол тодорхойлох, шалгах ажил хийгдсэн. Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барьж байгуулах ажлын талаар: Авто замын бүтээн байгуулалтын талаар - ҮТП-ийн асфальт бетон хучилттай 12.62 км авто зам барих /Багц-1/ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр гэрээ байгуулсан. Авто замын	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									гэрэлтүүлгийн /Багц-2/ ажлын гүйцэтгэгчийг мөн адил сонгон шалгаруулж, 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр гэрээ байгуулсан. Ажил гэрээ, төлөвлөгөөний дагуу явагдаж байна, гүйцэтгэл 35%-тай, гэрээний нөхцлийн дагуу 2024 оны 11 дүгээр сард бүрэн ашиглалтад орно. - “ҮТП-ийн авто замын техник, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр гэрээ байгуулан техникийн хяналтын ажлыг гүйцэтгэж байна. Төмөр замын бүтээн байгуулалтын талаар - Орхон аймаг Баян-Өндөр сум дахь “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Эрдэнэт өртөөнд байрлах “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын уул уурхай-металлурги-химийн ҮТП-ийн салбар 4,4 км төмөр замыг барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулсан. Ажил гэрээ, графикийн дагуу явагдаж байна, гүйцэтгэл 68%-тай, гэрээний нөхцлийн дагуу 2024 оны 7 дугаар сард бүрэн ашиглалтад орно. - ҮТП-ийн төмөр замыг барьж байгуулах ажилд зохиогчийн хяналт тавих ажлын гэрээг уг төмөр замын зураг төслийг боловсруулсан компанитай 2023 оны 5 дугаар	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									сард байгуулан, хяналт тавин ажиллаж байна. - “ҮТП-ийн төмөр замын ажилд тавих захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, хяналт тавин ажиллаж байна. Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын талаар - Ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төсвийг боловсруулан холбогдох төр захиргааны байгууллагаар баталгаажуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2022 болон 2023 онуудад удаа дараа зарлаж сонгон шалгаруулалтыг явуулсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд гэрээ байгуулах ажил хийгдэж байна. Гэрээний нөхцлийг 2023 оны 12 дугаар сарын 20-нд ажил бүрэн дуусахаар төлөвлөж байна. Цахилгаан хангамжийн зураг төсөл боловсруулах ажлын талаар - Цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг боловсруулж, 2022 оны 04 дүгээр сард Эрчим хүчний яамны ШУТЗ-ийн хуралд хэлэлцүүлэн батлуулсан. ЭХЯ-наас ҮТП-ийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөл болон зураг төслийн ажлын даалгавар гарсан. “ҮТП-ийн цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл”-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Зураг төслийн	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									хүрээлэн гүйцэтгэж байна, гүйцэтгэл 45%-тай. - Зураг төслийн ажлыг эрчимжүүлэх, төвөгшил өндөртэй зарим ажлуудыг төрийн өмчийн мэргэжлийн байгууллага болох “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨААТҮГ-тай хамтран гүйцэтгэж байна. Улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг хязгаарлах, хамгаалах ажлын талаар - Улсын тусгай хэрэгцээнд авсан ҮТП-ын газрыг хязгаарлах, хамгаалах зорилгоор тойруулан хашаа барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. Ажил гэрээний дагуу үргэлжилж байна, гүйцэтгэл 90%-тай. Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлын талаар - Монгол Улсад хүнд үйлдвэр, өнгөт металлургийн салбарыг хөгжлийн өндөр технологи шингээх зарчмаар кластер байдлаар хөгжүүлэх, үйлдвэрлэл, технологийн паркад ажиллах нэгжүүдийн ерөнхий бүдүүвчийг тодорхойлох зорилгоор “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор “Үйлдвэрлэл, технологийн парк”-ийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах ажлыг 2024 онд хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									Тулгамдаж буй асуудал - ҮТП байгуулахтай холбогдуулан шинээр 220/100/35 кВ-ын “Оюут” дэд станц болон ҮТП-ийн 110/35/6 кВ-ын дэд станцыг барьж байгуулах хөрөнгө оруулалт, санхүүжилтийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хариуцан гүйцэтгэж байна. ҮТП-ийн үйлдвэрүүд баригдаж эхлэх үед цахилгааны хэрэглээ эрс нэмэгдэх тул цахилгаан хангамжийн найдвартай нэмэлт эх үүсвэрийг одооноос төлөвлөн Эрчим хүчний яамнаас шийдвэрлэх шаардлагатай байна. Тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадал 15000 тн болсноор Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тэсрэх бодисоор хангах боломж бүрдэнэ. Ил уурхайн өрөмдлөг, тэсэлгээний хэсэгт эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр барих ажлыг “Монголиан Инвестмент Корпорэйшн” ХХК 2020.05.08-ны өдөр 7/006-20 дугаартай “Ил уурхайн Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг шинээр барих ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ” байгуулж ажил эхэлсэн. 2021.09.30-ны өдөр гэрээний хугацаа дуусаж. 2023.02.28-ыг хүртэл дахин сунгасан. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Барилга угсралтын ажил 85%,	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									технологийн тоног төхөөрөмжийн угсралт 95%. Ашиглалтад оруулах хугацааг 2023 оны 07 дугаар сар хүртэл сунгах хүсэлт ирсэн.	
7				"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлын явц, хувиар		50	146,556.0	Дотоодын хөрөнгө оруулалт	ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-ийг "ЭҮ" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-нд хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 \$/тн-ны түвшинд 762 сая ам.доллар буюу 2,171,700 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан. - ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. 2023.09.22-ны өдөр ирүүлсэн ажлын явцын тайланд тусгаснаар туршилтын үйлдвэрийн бүх тоног төхөөрөмж, барилга угсралтын ажил 100% дуусаж, туршилт эхлүүлэхэд бэлэн болсон. Үйлдвэрлэлийн туршилтын хамтарсан гэрээний дагуу "ЭҮ" ТӨҮГ нь туршилтад ашиглах 500 тн шигшсэн нүүрс бэлтгэх ажлыг 2023.07.20-ны өдрөөс 2023.08.26-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэж, БНХАУ-	50
							341,964.0	Гадаадын хөрөнгө оруулалт		

									руу тээвэрлэх ажлыг зохион байгуулан 2023.09.29-ний өдөр туршилтын үйлдвэрийн талбайд бүрэн хүргүүлсэн. Үйлдвэрлэлийн туршилтын ажлыг 2023.09.26-ны өдөр эхлүүлсэн. Туршилтын ажил үргэлжилж байна. - ЗБХБҮ-ийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын тендерийг "ЭҮ" ТӨҮГ-ын ЕЗ-ын 2022.08.08-ны өдрийн А/485 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2022.12.06-ны өдөр хуралдаж шууд гэрээ байгуулах журмаар зохион байгуулахаар шийдвэрлэж, техникийн даалгаврыг шинэчлэн боловсруулж байна. "ЭҮ" ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд уг ажлын төсөвт өртөгт шаардлагатай өөрчлөлтийг оруулан тусгаж, "Эрдэнэс монгол" ХХК-ийн ТУЗ-өөр батлуулсан. ENFI компаниас 2022.11.23-ны өдөр ирүүлсэн албан бичигтээ тус үйлдвэрлэлийн туршилтын ажил нь анхны төсөөллийг илүү тодруулж харуулахад чиглэгдсэн бөгөөд ЗБХБҮ-ийн төслийг хөгжүүлэхэд ямар нэг саад бэрхшээл болохгүй гэдгийг мэдэгдэж, ЗБХБҮ-ийг барьж байгуулах төслийн ажилд хөрөнгө оруулалт хийх, цаашид хамтарч ажиллах сонирхолтой байгаа илэрхийлсэн. - ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-д УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-өөс өгсөн зөвлөмжийн дагуу "Аж	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									үйлдвэрийн бүсэд мөрдөх агаарын чанарын стандартууд болон зэс хайлуулах үйлдвэрийн хаягдал утааны найрлага дахь агаар бохирдуулах бодисуудын ялгарлын олон улсын стандартуудыг судалж үндэсний болгон боловсруулж батлуулах" ажлыг гүйцэтгэж байна. Уг зөвлөх үйлчилгээний тендерт "Эс Ай Си Эй" ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. 60%-ийн санхүүжилт хийгдсэн. Ажлын явц 80%. Гүйцэтгэгч компанитай "ЭҮ" ТӨҮГ-ын ажлын хэсэг дундын тайланг хэлэлцэх хурлыг 2023.08.18-нд хийж, олон улсын туршлагыг судалсан судалгааны үр дүнд үндэслэн үндэсний болгон батлуулах стандартуудыг хэлэлцэж, 4-н стандарт сонгосон. Одоогоор стандартуудын эх хувийг авах, орчуулах ажил эхэлсэн бөгөөд зөвлөх багаар хянагдаж байна. Энэ нь ажил удаашрах шалтгаан болж, гэрээг 2024.01.28-ны өдөр хүртэл сунгах ажил хийгдэж байна. - Хүхрийн хүчлийг ашиглан фосфорын бордоо үйлдвэрлэх туршилт судалгааг "ЭҮ" ТӨҮГ-ын Судалгаа, шинжилгээний хүрээлэнгийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн "Фосфорын ордыг ашиглах урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг ШУТИС-ын УУХ-ГУУС-тай гэрээ	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									байгуулан ажиллаж, тайланг хүлээн авсан. - "Фосфорын ордыг ашиглах ТЭЗҮ боловсруулах ажил"-ыг төлөвлөсөн боловч фосфорын ордыг ашиглалтын лиценз хувийн компанийн эзэмшилд байдаг шалтгаанаар гүйцэтгэх боломжгүй болсон. - ЗБХБҮ-ийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг “Хатан далай” ХХК гүйцэтгэсэн. БОАЖЯ-ны мэргэжлийн комиссын 2023.08.30-ны хуралдаанаар тайланг хүлээн авахаар шийдвэрлэсэн. Ажлын явц 100%. - ЗБХБҮ-ийн техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж батлуулсан. Тендер хүчингүй болсон.	
8			"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр барих ажлын явц, хувиар	-	100	167,371.0	Дотоодын хөрөнгө оруулалт	Техник, эдийн засгийн үндэслэлийн талаар - Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах (SX/EW) технологиор боловсруулж, жилд 10.0 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр /Катодын зэсийн үйлдвэр/-ийн ТЭЗҮ боловсруулах ажлын гэрээг 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр байгуулан ажиллаж байна. - Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хурлаар дэмжигдэж, СТР/23-01-04 дугаар дүгнэлт гарсан ба Ашигт	50	

									малтмал, газрын тосны газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн “ТЭЗҮ бүртгэх тухай” Т/39 дугаар тушаалаар бүртгэсэн. - Катодын зэсийн үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хийж байна. Ажлын явц-63.8%, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/353 дугаар тушаалаар Катодын зэсийн үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийг боловсруулах ажилд хяналт тавих, гэрээг дүгнэх Ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. “ЭҮ” ТӨҮГ нь зураг төслийг боловсруулахад шаардлагатай Архитектор төлөвлөлтийн даалгавар, цахилгааны техникийн нөхцөлийг гэрээний хугацаанд гүйцэтгэгч “Майнинг шорт лонг терм” ХХК-д гаргаж өгч амжаагүй учир Ажлын хэсэг 2023.10.05; 30-ны өдрийн хуралдаанаас гэрээний хугацааг сунгах санал гаргаж “ЭҮ” ТӨҮГ-ын удирдлагад хүргүүлсэн. - Исэлдсэн хүдрийг SX/EW технологиор боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийлгэх ажлын тендерт “Төгрөг баян хангай” ХХК шалгарч, ажлын тайланг 2024.4.26-ны өдөр хүлээлгэж өгөхөөр “Эрдэнэт	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									үйлдвэр” ТӨҮГ-тай 2023.10.26-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Ажлын явц 30% - Исэлдсэн хүдэр боловсруулах катодын зэсийн үйлдвэрийн техник, технологийн түвшний үнэлгээ хийлгэх ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж, батлуулсан, тендер зарлахаар ажиллаж байна.	
9	2.4.2	МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.1	Стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн нүүрсний бүлэг ордын дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмж нэвтрүүлэх ажлын явц, хувиар	7	21	787,623.33	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Уурхайн үйл ажиллагаанд шаардагдах уулын үндсэн болон туслах техник нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нийт 14 багц тендерийг ТБОНӨХБАУХАТХ-н дагуу зохион байгуулж уулын үндсэн техникийн нийт 10 багцад шалгарсан нийлүүлэгчидтэй техник худалдах, худалдан авах гэрээг байгуулан хамтран ажиллаж байна. Тус гэрээний дагуу 2023 оны 12 дугаар сард 5ш бульдозер, 9ш автосамосвал, 3ш экскаватор, 2ш автогрейдер хүлээн авсан байна. Төслийн ажлын гүйцэтгэл 90%-д хүрсэн.	90
10				Конвейерийн систем нэвтрүүлэх ажлын явц, хувиар	3	43			“Конвейерийн системийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Мөн тус төслийн нүүрс тээврийн конвейерийн системийн худалдан авалтын үйл ажиллагааг нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцтай уялдуулан түлхүүр гардуулах нөхцөлтэй зохион байгуулахаар ажиллаж	30

								байна. “Эрдэнэс Монгол” ХХК-д конвейерийн ТЭЗҮ-ийг танилцуулсан. Эхний ээлжинд нүүрс тээврийн конвейерийн системийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерийг зарлахаар ажлын даалгаврыг боловсруулж дууссан. Тендер зарлахаар ажиллаж байна. Нийт ажлын гүйцэтгэл 15%-тай.	
11			Нүүрс ачилтын нэгдсэн төв байгуулах ажлын явц, хувиар	28	80			Тавантолгойн нүүрс ачих логиستيкийн төвийн батлагдсан ТЭЗҮ-д 2023 оны 4 дүгээр улиралд ашиглалтад оруулахаар төлөвлөсөн ч гүйцэтгэгчээс давагдашгүй хүчин зүйл учирсан шалтгаанаар төслийг 2024 оны 1 дүгээр улиралд хэрэгжүүлж дуусгахаар хойшлогдоод байна. Ачилтын нэгдсэн төв байгуулах төслийн гүйцэтгэл 84.34%-тай байна. Төслийн ихэнх овор хэмжээ томтой, голлох төхөөрөмжүүд угсрагдаж дуусаж байна. Төслийн нийт санхүүжилтэд 254 тэрбум төгрөгийг олгоод байна.	90
12			Нүүрс баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн ажлын явц, хувиар	10	80			"Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Норинко Интернэшнл Күүперэшн” компани болон “Дадиг инженеринг девелопмент групп” компаниудын түншлэл шалгаран 2022 оны 4 дүгээр сарын 14-нд гэрээ байгуулан ажиллаж байна. Нүүрс	70

									баяжуулах үйлдвэрийн 1-р модулын бүтээн байгуулалтын төслийн хэрэгжилтийг хурдасгах зорилгоор зураг төслийг хэсэгчлэн боловсруулж байгаа бөгөөд түүхий нүүрсний агуулахын зураг төслийг Барилга, хот байгуулалтын яамны харьяа Барилгын хөгжлийн төвийн 2133/2022 дугаар дүгнэлтээр 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр батлуулж, барилга угсралтын ажлын зөвшөөрлийг 2023 оны 02 сарын 16-ны өдөр авсан. Төслийн иргэний барилга буюу ажилчдын хотхоны зураг төслийг Барилга, хот байгуулалтын яамны харьяа “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-аар 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр батлуулсан бөгөөд барилгын ажлын зөвшөөрлийн хүсэлтийг Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 2023 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн дотор хүргүүлэхээр ажиллаж байна. Үндсэн үйлдвэр болон үйлдвэрийн бусад барилгуудын барилга байгууламж болон технологийн зураг төслийг магадлал хийлгэхээр “Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-т хүргүүлэн, эксперт томилуулж, хянуулах ажил хийгдэж байна. Инженер-геологийн судалгааны үр дүнгээс шалтгаалан ажилчдын хотхоны төлөвлөлтийг хойд зүгт шилжүүлэх шаардлага үүссэнтэй холбоотой төслийн	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									хэрэгцээнд нэмэлтээр 694.3 га газрын зөвшөөрөл авах ажлыг зохион байгуулж 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр газар эзэмшлийн гэрчилгээ авсан. Улмаар 2022 онд батлуулсан эскиз зураг, ерөнхий төлөвлөлтөд өөрчлөлт оруулж 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр дахин батлуулсан. Төслийн талбайд үндсэн үйлдвэр, түүхий нүүрс, бүтээгдэхүүний агуулах зэрэг үйлдвэрийн 22, ажилчдын хотхоны 5, нийт 27 барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг 30 гаруй компанийн 845 гаруй Монгол инженер, техникийн ажилтан, үүнээс гадна метал хийц, тоног төхөөрөмж угсралтын 223 гадаад ажилтан, 96 гаруй техник хэрэгслээр гүйцэтгэж байна. Төслийн хэмжээнд захиалагч болон гүйцэтгэгчийн нийт 1,240 гаруй ажилтан ажиллаж байна. Засгийн газрын 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлийн дагуу нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж байна. Мөн нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гэрээний үнийн дүнд тохируулга хийх нөхцөл байдал үүссэнтэй холбоотой 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 19 дүгээр тогтоолоор “Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									угсралтын ажлыг гүйцэтгэх” ЭТТ-2022/222 тоот гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан ба гэрээний үнийн дүнд 13.82%-ийн үнийн тохируулга хийж гэрээний нийт үнийн дүн 1,087,953,477,599.68 төгрөг болсон. Төслийн иргэний барилга буюу ажилчдын хотхоны зураг төслийг Өмнөговь аймгийн Онцгой байдал, Эрүүл мэндийн газар, Ерөнхий архитектораар тус тус батлуулан, 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Барилгын Хөгжлийн төвд хянуулахаар хүргүүлээд байна. Үндсэн үйлдвэр болон үйлдвэрийн бусад барилгуудын зураг төслийг Онцгой байдлын ерөнхий газраар батлуулж, 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Эрүүл мэндийн яамны салбарын хяналтын газарт хянуулахаар хүргүүлээд байна. Барилга, хот байгуулалтын яамнаас 2023 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 16-ны өдрүүдэд Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжийн угсралт, ашиглалтын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийсний хүрээнд Улсын ахлах байцаагчийн 02-00-02/008/195 дугаартай “Дутагдал арилгах тухай” албан шаардлагад нийт 42 дутагдал арилгахыг заасны дагуу өнөөдрийн байдлаар 20 дутагдал, зөрчлийг арилгаад байна. “Норинко Интернэшнл Күүперэшн” компани нь тус албан шаардлагад заасан 2, 4,	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									9, 10, 11, 13, 16, 21, 23, 27, 29, 30, 32, 34, 35, 38, 39, 40, 41, 42 дугаартай дутагдлуудыг арилгасан талаарх тайлангуудыг Барилга, хот байгуулалтын яаманд 2023 оны 11 дүгээр сарын 16 болон 21-ний өдрүүдэд тус тус илгээсэн. Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын ажлын зөвшөөрлөөс бусад зөрчил, дутагдлыг албан шаардлагад заасан хугацаа буюу 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс өмнө арилгах арга хэмжээг аван ажиллаж байна. Нүүрс баяжуулах үйлдвэрийн зураг төсөл бүрэн батлагдсаны дараа барилгын ажлын зөвшөөрлийг авахын тулд Барилга, хот байгуулалтын яам болон холбогдох байгууллагуудад батлуулахаар хүргүүлэх бөгөөд тус үйл ажиллагаанд хамгийн багадаа хоёр сарын хугацаа зарцуулагддаг тул хугацааг сунгах хүсэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Өнөөдрийн байдлаар зураг төслийн гүйцэтгэл 96%, тоног төхөөрөмжийн худалдан авалт 73%, барилгын материалын худалдан авалт 94%, тоног төхөөрөмж, барилгын материалын тээвэр 64%, барилга болон тоног төхөөрөмжийн угсралт 34%-тай тус тус явагдаж байгаа ба төслийн нийт гүйцэтгэл 12 дугаар сарын 26-ний байдлаар 64.41%-тай байна.	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

13	2.4.3	МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.1	Стратегийн ач холбогдол бүхий Оюутолгой ордын далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	Бүтээн байгуулалтын ажлын явц, хувиар	78	89	497.0 сая.\$	Гадаадын хөрөнгө оруулалт	2023 оны 12-р сарын 20-ний байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 92.1%, налуу амны туузан дамжуургын угсралтын ажлын гүйцэтгэл 84.3 хувь, баяжуулах үйлдвэрийн өргөтгөл 33.6 хувь, агааржуулалтын 3-р босоо амны нэвтрэлт 865 метрт, агааржуулалтын 4-р босоо амны нэвтрэлт 959 метрт тус тус хүрээд байна. Далд уурхайгаас хүдэр олборлолтын ажил явагдаж байна. Цаашид налуу амны дэд бүтцийн угсралтын ажил, агааржуулалтын босоо амнууд болон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулснаар далд уурхайгаас хүдэр гаргах хүчин чадал төслийн хүчин чадалдаа хүрнэ. 2023 оны 11 сарын байдлаар далд уурхайн бүтээн байгуулалтад нийт 5,961 сая ам.долларыг зарцуулсан бөгөөд 2023 онд 497 сая ам.долларыг зарцуулаад байна.	90
14	2.4.5	МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ-3.2.3	Геологийн зураглал, судалгааны ажлыг эрчимжүүлэн, гео мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, үйлчилгээг цахимжуулах	Геологийн 1:50000-ны масштабын зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар	41.9	46	Улсын төсөв Батлагдсан: 6,646.0 Гүйцэтгэл: 6,600.7 Санхүүжилт: 5,866.3	Улсын төсөв	Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн “Хулд уул-50”, “Түдэвтэй уул-50”, “Дэвийн хонгор уул-50”, “Асгат уул-50” төслүүдийн үр дүнгийн тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2023 оны 04 дүгээр сарын 10, 11, 14-ний өдрүүдэд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 13,150.3 км ²	90

									талбай буюу 0.84%, нийтдээ 43.94%-ийг хамруулсан. Үүнд: - <u>Давхарга зүйн</u> 46 формац, гүний болон бага гүний 19 бүрдлийг ялган зурагласан. - <u>Ашигт малтмалын хувьд</u>: зэсийн 3, хар тугалга-цайр 1, марганец 1, лити 1, төмрийн 6, жонш 1, гантиг 1, өнгөлгөөний чулуу 3, элс, шавар, хайрганы 3, кварцын 1 нийт 21 илрэл, 144 эрдэсэжсэн цэг, 134 геохимийн сарнилын хүрээ, 129 шлихийн сарнилын хүрээг тогтоож, мөнгө 3,085 кг, зэс 216,496 тн, цайр 23,629 тн, сурьма 19,500 тн, вольфрам 12,500 тн, молибден 13,800 тн, никель 8,700 тн, хар тугалга 16996 тн, хүнцэл 647,700 тн, төмөр 5,825,516 тн, мангани 53,398 тн, өнгөлгөөний чулуу 30,000 куб.м, шавар 4,628,000 сая.тн таамаг нөөцийг тогтоож, Р зэрэглэлээр үнэлгээг өгч хамгаалагдсан. • Үргэлжлэн хэрэгжиж буй 25 төслийн геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар тогтоогдоод байгаа ашигт малтмалын үр дүнгээр: 1. Бөгрөг уулын зэсийн илрэл; 2. Хороот уулын зэсийн илрэл; 3. Улаан толгойн зэсийн илрэл; 4. Урчуудын хөндийн алт-зэсийн илрэл; 5. Дэвсэнгийн алтны илрэл; 6. Улт улааны төмрийн илрэл; 7. Хөндлөнгийн бал чулууны илрэл; 8. Хөндлөн худгийн зэс-алтны илрэл; 9. Шавар худийн зэсийн илрэл; 10. Хүрэн бүстийн зэсийн илрэл;	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									11. Булагтын вольфрамын илрэл; 12. Цахир-Уулын алтны илрэл; 13. Баян-Өндөрийн алт-мышъякын илрэл; 14. Эхэн-Усны зэсийн илрэл; 15. Зүүн-Уужимын алт-мышъякын илрэл; 16. Цагаан толгойн алт-мышъякын илрэл; 17. Дунд-Уужимын мышьяк-сурьмагийн илрэл; 18. Мөргөцөг худгийн алт-мышъякын илрэл; 19. Бүлээн булгийн полиметаллын илрэл; 20. Хүрэн хадны алт-мышъякын илрэл; 21. Хөх нуурын шаврын илрэл; 22. Хяртын нуурын шаврын илрэл; 23. Баян уулын элсний илрэл; 24. Доод Нарийны голын алтны шороон илрэл; 25. Сүмбэр уулын бал чулууны илрэл; 26. Жалга нэртэй Манганы илрэл. Үүнээс гадна илрэл болох нь тогтоогдсон нэршил өгөгдөөгүй Алт-7, Алт-мышъяк-7, Зэс-7, Холимог металл-1, Манган-2ш, Мышьяк-3ш, Молибден-1, Висмут- 2, Гипс-2, Нүүрс-3, Үнэт эрдэнийн чулууны-2, Гоёлын чулууны 1 илрэл, Барилгын материалын түүхий эдийн 1 нийт 65 илрэлүүдийг тогтоогдсон бөгөөд Эрдэсэжсэн цэг 848, Цэгэн гажил 1093 лабораторийн шинжилгээний үр дүнгээр тогтоогдсон.	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

								Мөн төслүүдийн хэрэгжилтийн явцад баялгийн үнэлгээг Р зэрэглэлээр тооцож үнэлсэн дараах үр дүн гарсан байна. Үүнд: <u>“Ширээт уул-50” төсөл:</u> Бумбатын төмрийн илрэл: 22,384,185 тонн; <u>“Цэцэрлэг-50” төсөл:</u> Гозгор-Улаан уул илрэл: хартугалга 14,448 мян тн, зэс 2.484 мян тн, цайр 14.6 мян/т, <u>“Үнэгт-50” төсөл:</u> Улт улаан илрэл: Fe-7200 мян.тн, Mn-288мян.тн, Оргиоч илрэл: Mn-40мян.тн, Дэвсэн илрэл: Mn-13мян.тн, Баян-Уул: Au-C-2800 кг, P-4800 кг, Si-8000мян.тн, Mo-400мян.тн, Гурван овоо илрэл: Si-7000мян.тн, Mo-200мян.тн, Хөх ус илрэл: As-5.4мян.тн, Жаргалант шатах занарын илрэл: 1480 сая тонн, Төхөм шатах занарын илрэл: 1280 сая тонн, Өндөрсант: Au-67 кг, хайлуур жонш 3.3мян.тн, Төхөмийн нуурын шүүний илрэл: 60мян.тн, Эрдэнэ сант тоосгоны шавар: B+C 86.0мян.тн; <u>“Хайрхан овоо-50” төсөл:</u> Зүрх уулын илрэл: зэс- 141375мян.тн, Гантиг-1 өнгөлгөөний чулуу 17100м.куб, Гантиг-2 өнгөлгөөний чулуу 2250000м.куб, Элс-1, барилгын элс: 66500м.куб, Элс-2: барилгын элс 6750м.куб, Дайрга: 359100м.куб, Тоосгоны шавар: 383600м.куб; <u>“Торлог уул-50” төсөл:</u> Булган илрэл: Be 1350, Хундагт илрэл: Li-2386тн, Улаан толгой илрэл: Be-400тн, Li- 364тн, Rb-509тн, Дээд
--	--	--	--	--	--	--	--	---

								нарийн илрэл: Cu-390000тн, Хар чулуут илрэл: Fe-954630тн, Хар хад титаны илрэл: 67600тн, Баруун булганы элсний илрэл: 480,000куб/м, Ус нуурын ам элс-хайрганы орд: 891.7куб/м, Өвдөг шохойн чулууны илрэл: 2.06 сая.т; <u>“Оорцог уул-50 төсөл”</u>: Өндөр Хаан уулын төмрийн илрэл: 1809(тн), Холбоо толгойн худгийн баруун төмрийн илрэл: 18341(тн), Холбоо толгойн худгийн төмрийн илрэл: 83377(тн); <u>“Их хараат уул-50” төсөл</u>: Шилний түүхий эд Р1 зэрэглэлээр 95,4 сая.т, Өнгөлгөөний чулуу Р1 зэрэглэлээр 95,4 сая.м3; <u>“Зангаат-50” төсөл</u>: Цахирт Уул илрэл: Алт-3.5тн, Булагт илрэл: Вольфрам-63.4тн, Эхэн-Ус илрэл: Зэс-51800тн, Хөндлөн худаг илрэл: Бал чулуу-21300тн, Улаан өндөр илрэл: Зэс-24300тн, Алаг уул илрэл: Зэс-4200тн, Улаан толгой илрэл: Зэс-19200тн, Сэвхүүлийн худаг илрэл: Зэс-2500тн, Бунхант худаг Зэс-6600тн; <u>“Өндөр ширээт-50” төсөл</u>: Өлзийт илрэл: Au-3.78 кг, Ag-11.34 кг, Дэндгэр илрэл: Fe-158.3 тн, Mn-9.0 тн, Cu-133 тн, Хараат: Fe-65.9 тн, Mn-3.0 тн, Cu-84 тн, “Хөх нуурын” илрэлийн талбай: (P2) Au-4,53т, Pb-1,2 мян.тн, As 6,3 мян.т таамагласан баялаг; <u>“Овоот толгой-50” төсөл</u>: Чулуут толгой илрэл: Cr-16,5 мян.тн, Ni-18 мян.тн, Co 3,6 мян.тн, Хар нуурын шаврын 6.6 сая.куб.м, элсний 21.2 сая.куб.м, Хяртын нуурын шаврын 15 сая.куб.м, Тээлийн голын элсний 40.5 сая.куб.м, шаврын 4.86 сая.куб.м	
--	--	--	--	--	--	--	--	--	--

								“Хар хайрхан-50” төсөл: Шар тээг илрэл: нүүрс 101,211,466тн, Номингийн хөндий нүүрсний илрэл: 45,798,128тн, Сүүж-Уул Ау-42кг, Хар хошуу Си-1,656,000тн, Талынтолгой Си-42757тн, Мо-8.6тн, Хойд хөндлөн Си-236250тн, Ау-47кг, Цагаанбургас Мо-73953тн, Си-284882тн, Мөргөцө гипсний илрэл: 986344тн, Цав гипсний илрэл 258635тн; “Их бэрх уул-50” төсөл Их бэрхийн төмрийн 68.6мян/т, элсний илрэл 150мян/т, хайрганы илрэл 500мян/т, Өнгөлгөөний чулууны илрэл-15000мян/т, Шохойн чулууны илрэл 4000мян/т.	
15			Геологийн 1:25000-ны масштабын зураглал бүхий газар нутгийн хэмжээ, хувиар	-	0.1	-	Улсын төсөв	Үндэсний геологийн албанаас 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажил гүйцэтгэх чиглэл, агуулга, бүтцийн талаар ҮГА-ны холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтэнүүдтэй санал солилцсон. Чех улсын геологийн албаны болон ОХУ-ын геологийн салбарт ашиглаж байгаа зураглалын ажлын заавартай танилцаж судалж байна. ҮГА-наас заавар, түүнд тавигдах шаардлагын төслийн саналыг ирүүлээгүй байгаа тул гүйцэтгэл гаргах боломжгүй байна.	0
16			Геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг хийх талбайн хэмжээ, хувиар	68	100	Улсын төсөв Батлагдсан: 456.3 Гүйцэтгэл: 435.6 Санхүүжилт:	Улсын төсөв	1. Монгол орны “М” хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх төслийн 2023 оны төсвийг УУХҮСайдын А/21 дүгээр тушаалаар 456,395,566 төгрөгийн ажлыг баталсан. Төслийн хэмжээнд 2023	70

							427.5	онд гүйцэтгэсэн ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр “Хээрийн материал хүлээн авах ажлын хэсэг” хянан хүлээж авсан. Үүний үр дүнд Монгол орны нутаг дэвсгэрийн М хавтгайн хэмжээнд хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусгаж, эцсийн үр дүнгийн тайланг Монголын геологийн зургийн редакцын зөвлөлөөр хянагдаж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. 2. Монгол орны “L” хавтгайн хэмжээнд хийгдсэн Улсын геологийн 1:200000-ны масштабтай иж бүрдэл зургийг нэгтгэх ажлын үр дүнд “L” эгнээний нийт 160, нэгтгэснээр 152 хавтгайн “УГЗ-200” иж бүрдлийн геологийн, ашигт малтмалын, дөрөвдөгчийн геологийн, экологи-геологийн, баримт материалын шинэчилсэн зургуудыг зохиож, тоон мэдээлэлд оруулж, мэдээллийн санг нь шинэчлэж “УГЗ-200” иж бүрдлийн хоёрдугаар хэвлэлийг бэлтгэсэн. <u>Ашигт малтмалын зурагт:</u> минерагений бүс 42, хүдрийн дүүрэг болон хүдрийн потенциал дүүрэг 169, хүдрийн зангилаа болон хүдрийн потенциал зангилаа 241, сав газар, потенциал сав, хүдрийн талбай болон хүдрийн потенциал талбай 132,, нүүрст талбай, 167 бүлэг (илрэл, эрдэсжсэн цэг, шлих, геохимийн хүрээ)-ийн жагсаалтыг өгч, ашигт малтмалын зурагт доорх хүснэгтд тусгасан 100 төрлийн ашигт малтмалыг хамааруулсан. Үүнд:	
--	--	--	--	--	--	--	-------	---	--

								Мангаан, Хром, Хайлуур жонш, Титан, Барит, Ванади, Стронцианит, Целестин, Зэс, Алунит, Галт уулын шаарга, Хар тугалга, Цайр, Фосфорит, Никель, Кобальт, Кварц, Шохойн чулуу, Молибден, Шилний элс, Гангиг, Вольфрам, Хээрийн жонш, Доломит, Цагаан тугалга, Каолин, Мергель, Хөнгөнцагаан, Силлиманит, андалузит, Магни, Мөнгөн ус, Гранат, Цементийн шавар, занар, Хүнцэл (мышьяк), Сурьма, Шөрөмсөн чулуу (асбест), Дээврийн занар, Висмут, Мусковит, Тальк, Элс-хайрганы холимог, Берилли, Магнезит, Барилгын элс, Лити, Цеолит, Элсжин, Тантал, ниоби, Бал чулуу, Дайрга, Кадми, Германи, Мана, гартаам, Гөлтгөнө, Циркони, Чулуужсан мод, Кварцын элс, Церийн бүлгийн ГХЭ, Усан биндэрьяа, Өрөмдлөгийн шавар (Бентонит), Иттрийн бүлгийн ГХЭ, Ягаан болор, Эрдсийн будаг болох шавар, Цагаанхаш, Алт, Волластонит-везувиан, Глауконит, Мөнгө, Тремолит, Цагаан алт, Лиственит, Хүнсний давс, Улаан, улаан хүрэн хас, Мөсөн шүү, Уран, Турмалин, Байгалийн соод, Тори, Хризопраз, Эпсомит, Саран чулуу, Тенардит, Газрын тос, офиокальцит, Чулуун нүүрс, Хүрэн нүүрс, Шатдаг занар, Хүлэр зэргийг хамруулсан. Ашигт малтмалын зургуудад нийт: 11614 орд, илрэл, эрдэсжсэн цэг тусгагдсан ба үүнээс металл ашигт малтмал-2246, шороон хуримтлал-369, үйлдвэрлэлийн	
--	--	--	--	--	--	--	--	---	--

								эрдсийн ашигт малтмал-1071, металл ба үйлдвэрлэлийн эрдсийн эрдэсжсэн цэг-6569, шатдаг ашигт малтмал-375, эрдэс давс-98, барилгын материал-845, рашаан ус-41 байсан. Мөн 13653 тооны шлих, геохимийн цэгэн гажил, хүрээ тусгагдсан. Энэ бүх объектуудын мэдээллийн сан нь шинэчлэгдсэн.	
17			Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгаа бүхий нутаг дэвсгэрийн хэмжээ, хувиар	65	68.1	Улсын төсөв Батлагдсан: 2,187.0 Гүйцэтгэл: 1,788.5 Санхүүжилт: 86.9	Улсын төсөв	“Ховд-2020” 1:200000-ны масштабын агаарын геофизикийн судалгааны ажил: Судалгааны ажлын үр дүнд: -Нийлбэр соронзон орны эрчимжилтийн зураг; -Туйлын засвар хийсэн нийлбэр соронзон орны зураг; -Нийлбэр цацраг идэвхжилийн зураг (Tcnt); -Газрын калийн агуулгын зураг (K); -Газрын торийн агуулгын зураг (Th); -Газрын ураны агуулгын зураг (U) буюу нийт 6 төрлийн зураг 104044 кв.км талбайн хэмжээнд тайлбар бичгийн хамт зохиогдож, үр дүнгийн тайлан Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдаж, хурлын товыг хүлээж байна. Төслийн талбайд гүйцэтгэсэн агаарын геофизикийн судалгааны үр дүнгээр илэрсэн геофизикийн гажил шалгах, газрын тодруулалтын ажил хийхээр нийт 15 талбай сонгож, газрын эрэл-шалгалтын ажил хийсэн. Тухайлбал: ГХЭ-ийн 6 илрэл, 10 эрдэсжсэн цэг, 45 цэгэн гажил,	70

								зэсийн 1 илрэл, 15 эрдэсэжсэн цэг, 4 цэгэн гажил, цайрын 10 цэгэн гажил, мангаани 1 цэгэн гажил, стронцийн 6 цэгэн гажил, титаны 6 цэгэн гажил, берилли 4 цэгэн гажил, вольфрам 3 цэгэн гажил, ванади 2, ураны 5 цэгэн гажлууд илрүүлсэн. Нийт 5 талбайг ГХЭ-ийн эрлийн хувьд сонирхолтой, 1 талбайг алт-зэсийн хувьд сонирхолтой гэж дүгнэсэн. Мөн шүлтлэг гранитоидтой холбоотой ГХЭ-ийн эрэл, эрэл-үнэлгээний ажил явуулах шаардлагатай 'А' зэрэглэлийн 2 талбай, 'Б' зэрэглэлийн 11 талбай, скарны төрлийн төмрийн хүдэржилтийн хувьд хэтийн төлөв сайн 'А' зэрэглэлийн 2 талбай, 'Б' зэрэглэлийн 7 талбай, тунамал, вулканоген-тунамал, интрузивтэй холбоотой судал, штокверкийн төрлийн төмрийн хүдэржилт илрүүлэх хязгаарлагдмал хэтийн төлөвтэй 'В' зэрэглэлийн 5 талбай, элсэн чулуунд агуулагдах ураны тунамал гаралтай хүдэржилтийн хэтийн төлөвтэй 'Б' зэрэглэлийн 4 талбай, шүлтлэгдүү гранитоидтой холбоотой хязгаарлагдмал хэтийн төлөвтэй 'В' зэрэглэлийн 4 талбайд хэтийн төлөвийн үнэлгээ өгсөн.	
18			Геологийн зураглалыг төрөлжүүлж, шинээр болон үргэлжлүүлэн хийх судалгааны ажлын тоо	15	24	Батлагдсан: 11,676.40 Гүйцэтгэл: 10,953.52 Санхүүжилт: 9,144.78	Улсын төсөв	<u>1. "Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа" төсөл:</u> Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа "УБ геоэкологи-2017" төсөл ЭБМЗ-ийн 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн /УТХ-2023-06	90

									дугаар/ хуралдаанаар хэлэлцүүлэгдсэн. Хурлаар төслийн үр дүнгийн тайланг Монгол Улсын геологийн мэдээллийн санд хүлээн авах дүгнэлт гарсан. <u>Хийгдсэн ажил:</u> "УБ геоэкологи-2017" төсөл нь 4707,4.4 км2 талбайн хэмжээнд 1:25000-ны масштабын 85 хавтгайд баримт материалын зураг, геоэкологийн зураг, гидрогеологийн зургийг тус бүр, 1:50000-ны масштабаар геологийн зураг 4 хавтгай, геоморфологийн зураг 24 хавтгай, мөн дагалдах зургуудыг тус тус зохиож, өгөгдлийн сангийн тоон системд оруулсан. <u>Үр дүн:</u> Улаанбаатар хотын нутаг дэвсгэр, Багануур, Багахангай, Баянгол, Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт энэхүү төсөл хэрэгжсэн. Судалгааны үр дүнд төслийн талбайн хэмжээнд хүний эрүүл мэндэд хортой хүнд элементийн тархалтын зургийг гаргасан ба анхаарал татах объектуудыг судлан бохирдолтын эх үүсвэр түүнийг саармагжуулах зөвлөмж өгсөн. Улаанбаатар хотын нийт хүн амын 95.2 хувь нь төвийн 6 дүүрэгт, 4.8 хувь нь алслагдсан 3 дүүрэгт тус тус оршин сууж байгаагаас төвийн зургаан дүүрэгт хүн ам хэт төвлөрсөн байдал ажиглагдаж байгаа тул цаашид хот төлөвлөлтийг Багануур Багахангай дүүргүүдэд өсөн тэлэх боломж үүсгэн, хүн амын тав тухтай, таатай	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх, газар хөдлөлийн судалгаанаас үзэхэд Хустайн болон Гүнжийн хагарлын дагуу хотын барилгажсан хэсгүүдэд эрсдэл хамгийн өндөр байгаа тул Улаанбаатар хот дахь байшин барилгууд 9 баллд тэсвэртэй байх ёстой тул нарийвчилж газар хөдлөлтөд тэсвэртэй эсэхийг тогтоох шаардлагатай бөгөөд шинээр төлөвлөгдөж байгаа төслүүдэд анхаарал зөвлөмж өгөгдсөн. Энэхүү төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын хэмжээнд геологи болон гидрогеологи, геоэкологийн нэгдсэн зураг гарсан бөгөөд геогамшиг, усан хангамж, газар нутгийн төлөвлөлтийг тодорхой объект, талбайг сонгон хийх тохиолдолд суурь мэдээлэл бүрдсэн. Төслийг хэрэгжүүлснээр хүн ам, үйлдвэр, аж ахуй нэгжүүд бүхий нягтаршил ихтэй томоохон хотын хэмжээнд геоэкологийн судалгаа хийх зааврын төсөл хийгдсэн. Байгаль орчны яам, Барилга хот байгуулалтын яам, Эрдэнэт хотын захиргаа зэрэг төрийн байгууллагад төслийн үр дүнгийн тайлангийн хуулбар хувийг хүргүүлэн тус хотын цаашдын төлөвлөлт, нийгмийн олон талт асуудлыг шийдвэрлэхэд суурь мэдээлэл бүрдсэн тухай мэдэгдсэн. <u>II. “Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа” төсөл:</u> Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа “ЭР	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									геоэкологи-2019" төсөл ЭБМЗ-ийн 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн /УТХ-2023-06 дугаар/ хуралдаанаар хэлэлцүүлэгдсэн. Хурлаар төслийн үр дүнгийн тайланг Монгол Улсын геологийн мэдээллийн санд хүлээн авах дүгнэлт гарсан. "ЭР геоэкологи-2019" төсөл нь 1945.03 км² талбайн хэмжээнд 1:25000-ны масштабын 23 хавтгайд баримт материалын зураг, геоэкологийн зураг, гидрогеологийн зургийг тус бүр 1:25000-ны масштабаар 23 хавтгайд, геоэкологийн суурь үнэлгээний зургийг 1:50000-ны масштабаар 10 хавтгайд, геоморфологи, ландшафт, хөрсний зургийг 1:25000-ны масштабаар тус тус зохиож, өгөгдлийн сангийн тоон системд оруулсан. <u>Үр дүн:</u> Эрдэнэт уурхайг түшиглэн байгуулагдсан хотын талбайн хэмжээнд геоэкологийн судалгааны үр дүнг нэгтгэж, уурхайн үйл ажиллагаанаас улбаатай цагаан тоосны тархалт, түүнийг багасгах, ажиглалт судалгаа хийх, мөн үйлдвэрийн хаягдалаас шалтгаалсан бохирдол хөрс усанд нэвчих нөлөөлөлийг бууруулах зөвлөмж өгсөн. Цаашид хотын хүн амын нягтаршил түүнийг даган бий болсон техноген үйл ажиллагаанаас үүдэн бий болсон бохирдолыг бууруулах, агаар, хөрс, газрын доорх болон гадаргын усны ашиглалт,	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									хамгаалалтын талаар дүгнэлт зөвлөмж өгсөн. Бусад хоттой харьцуулахад цаашид Эрдэнэт хот нь тэлэлт хийх талбай бага тул ашиглалтад оруулж болох талбай сонголтыг зөвлөмжинд оруулав. Энэ төслийг хэрэгжүүлсэнээр Монгол улсад уул уурхай даган шинээр бий болж буй суурин газарт геозкологийн судалгаа хийж суурь мэдээлэл бүрдүүлэх боломж бүрдсэн. Байгаль орчны яам, Барилга хот байгуулалтын яам, Эрдэнэт хотын захиргаа зэрэг төрийн байгууллагад төслийн үр дүнгийн тайлангийн хуулбар хувийг хүргүүлэн тус хотын цаашдын төлөвлөлт, нийгмийн олон талт асуудлыг шийдвэрлэхэд суурь мэдээлэл бүрдсэн тухай мэдэгдсэн. <u>III. "Дархан хотын геозкологийн, гидрогеологийн судалгаа" төсөл:</u> Төсөл 2020-2023 онд хэрэгжинэ. Дархан геозкологийн төсөл нь 2605,7 км² талбайд 1:25000-ны масштабын 31 хавтгайг хамарна. 1. Хийгдсэн ажил: Төсөл хэрэгжих хугацаанд геозкологийн төрөлжүүлэлтийн зураг, гидрогеологийн зураг 1:25000-ны масштабтай, геологийн, геоморфологийн зураг 1:50000-ны масштабтай зургууд тус тус зохиогдсон. Төслийн үр дүнгийн тайланг зохиосон бөгөөд ҮГА тайланг хянаж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх шаардлага хангах засвар нэмэлт өөрчлөлт хийх чиглэл өгсөний дагуу засвар хийж байна.	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									<u>IV. Ховд хотын геоэкологи, гидрогеологийн судалгаа Ховд геоэкологи-2021 төсөл:</u> Төсөл 2021-2023 онд хэрэгжиж байгаа бөгөөд хээрийн ажил дуусч боловсруулалтын ажил хийгдэж байна. Нийтдээ 1978 км2 талбайд 23 хавтгайг хамарна. Хийгдсэн ажил: Геоэкологийн болон гидрогеологийн зураг 1:25000 масштабтайгаар нийт 23 хавтгайд, геологи, геоморфологийн зураг 1:50000-1:100000-ны масштабтайгаар тус тус зохиогдсон. Төслийн үр дүнгийн тайланг зохиосон бөгөөд ҮГА тайланг хянаж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх шаардлага хангах засвар нэмэлт өөрчлөлт хийх чиглэл өгсөний дагуу засвар хийж байна. <u>V. Монгол орны төв болон хойд хэсгийг хамрах 602,984.0 км2 талбайд гүний хагарал, түүнтэй холбоотой рашаан булгийн судалгааны "Гүний хагарал-1" төсөл:</u> Хийгдсэн ажил: - Гүний хагарлын судалгааны ажлаар төслийн талбайд Монгол орны тектоникийн муж, бүсүүдийг зааглагч гол структуруудыг ялган, мөрдөн шалгах, зураглах, зүсэлт хийх, ажиглалт хийх ажлууд хийгдсэн. - Идэвхтэй хагарлын судалгааны чиглэлээр нийт 160 орчим идэвхтэй болон идэвхтэй байж болзошгүй гэж үзсэн хагарал түүний сегментүүдийг шалгаж, зураглах, мөрдөх ажлыг хийж гүйцэтгэсэн.	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									- Палеосейсмологийн судалгааны ажлаар хагарлын маршрутын судалгаа, морфологи-структурын судалгаа хийж гүйцэтгэсэн Моностой, Авдар, Хаг нуур хагарлууд болон Идэр, Эрхэл нуур, Хужирт, Тоом гол, Хогоргын хагарлуудад судалгааны ажил хийгдсэн. - Морфологи структурын судалгааг дээр дурдсан палеосейсмологийн судалгаа явуулж буй 8 хагарал болон Булнай, Баян-Агт, Эрчим, Цэцэрлэг, Дүнгэнээ, Таацын гол, Эгийн даваа, Өмнөд хангай зэрэг хагарлуудад 1-2 талбайд Дроны зураглалын ажлыг хийж гүйцэтгэсэн. - Геотермийн судалгааны ажлын хүрээнд дөрөвдөгчийн вулканоген чулуулаг тархсан талбайнуулыг бэлтгэл ажлын хүрээнд ялгаж, Өгий нуур, Орхон, Тариат, Өгөөмөр-Богд, Урантогоо гэсэн 5 районд судалгаа хийгдсэн. - Гидрогеотермийн судалгаа: Хужирт, Их Шаргалжуут, Отгонтэнгэр, Цэнхэр, Хульж, Хөнжил зэрэг халуун рашаануудад гидрогеотермийн судалгаа хийсэн. - Гидрогеологи, рашаан булгийн судалгаа: Нийт 192 орчим рашаан, булаг, эрдэст нуурт хүрч 186 рашаанд хэмжилт, бичиглэл, дээжлэлт, гидрогеологийн маршрутын судалгааны ажил хийж гүйцэтгэсэн. - Геоэкологийн судалгаа: Рашаан болон рашаан түшиглэн үйл ажиллагаа явуулж буй	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									амралт сувилалын газруудын үйл ажиллагааны өнөөгийн байдалд геоэкологийн судалгаа хийсэн. <u>VI. Монгол Улсын босоо тэнхлэгийн бүсэд 2022-2024 онд хэрэгжүүлэх гео-орчин төсөл:</u> Төслийн талбай нь Улаанбаатар хот болон Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Төв, Говьсүмбэр, Дорноговь зэрэг аймгуудын нутгийн, нийт 41 сумын нутаг дэвсгэрийн 52659.0 кв.км талбайг хамарна. Төслөөр Монгол улсын босоо тэнхлэгийн дагуух уул уурхайн бүтээн байгуулалт явагдаж буй бүс нутаг, хилийн боомт, шугаман байгууламж буюу автозам, төмөр зам, хийн хоолой дагуу хэсгийн 100км-ийн зурваст геоэкологи, Биологи, Геогамшиг, Аялал жуулчлал, Инженер геологи, дэд бүтцийн байгууламжид ашиглагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын тархалтын талаар судалгааг хийж байна Геоэкологи, геоморфологи, гео-орчин судалгаа: сансрын зурагт урьдчилан тайлсан гео-орчны зургийг газар дээр шалган баталгаажуулах зорилгоор маршрутын судалгааг 11 хавтгайн хэмжээнд 4203 т.км маршрутын ажил хийж 1554 цэгт ажиглалт бичиглэл хийсэн. Техноген объект дахь геоэкологийн судалгаа: 11 объект бүхий нийт 234 кв.км талбайд хийж, Айрагийн уурхай, Айраг сум, Даланжаргалан сум, Шивээговь	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									сум, Баянтал сум зэрэг 7 объектын 28 кв.км талбайд дроны зураглалын ажил хийж, боловсруулалтын ажил хийгдсэн. Гидрогеологийн судалгаа: Нийт 380 ажиглалтын цэгт анхдагч судалгаа, бичлэгийг хийсэн. Гидрохимийн шинжилгээнд зориулж 320 ширхэг усны дээж авч, 42 худагт богино хугацааны сорилын шавхалт хийж, худгийн ундарга, ус агуулагч чулуулгийн шүүрэлтийн итгэлцүүрийг тодорхойлсон. Гидрологийн судалгаа: Улаанбаатар хотоос хойш Төв, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн нутгуудад хийж 277 ажиглалт хэмжилтийн ажил, үүнээс усны чанарын хээрийн хэмжилт 84, гидрометрийн 67 хэмжилтийг хийгдсэн. Хээрийн судалгаагаар гол, нуур, цэвэрлэх байгууламжийн 84 дээж авсан. Эрлийн ажил: Түгээмэл тархацтай ашигт малтмалын хэтийн төлөвтэй байж болох элсний 6, элс-хайрганы холимогийн 12, шаврын 2, барилгын чулууны 16, өнгөлгөөний чулуу 4, нийт 40 илрэл тогтоосон. Геофизикийн ажил: Түгээмэл тархацтай ашигт малтмалын 15 талбай, цэвдэгийн судалгааны 2 талбай нийт 17 талбайд геофизикийн судалгааны ажил хийгдсэн. Улсын төсвийн хөрөнгөөр 2022-2023 онуудад эхлүүлэх төслийн саналд "Тектоник-2021" төслийн саналыг боловсруулж,	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									холбогдох материал, тооцоо, судалгааг хийсэн. Өнөөдрийн байдлаар тухайн төслийг эхлүүлэх зайлшгүй шаардлагагүй гэж үзсэний үндсэн дээр төслийн ажлыг эхлүүлээгүй. Ханбогдын дүүрэгт гүйцэтгэх геохимийн судалгааны ажил төслийг 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Гео-Эрин” ХХК болон “Баялаг дата минералс” ХХК-ийн түншлэлтэй геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээг байгуулан, төслийг шинээр эхлүүлж 2023 онд гүйцэтгэх гэрээний үнийн дүнгийн нийт ажил буюу төслийн нийт талбайд 500х250м тороор авахаар төлөвлөсөн 7706ш дээжийг 100% авч лабораторийн шинжилгээнд хамруулсан. Ханбогдын дүүрэгт гүйцэтгэх геофизикийн соронзон судалгааны ажил; төслийг 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Геологийн судалгаа шинжилгээний төв” ТӨҮГ-тай геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээг байгуулан, төслийг шинээр эхлүүлсэн. Төслийн хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 04-өөс танилцах маршрут 10т/км, эрэл-шалгалтын маршрутыг 30т/км хийж нийт 30ш цэглэн сорьцлолт авч шинжилгээнд хамааруулсан. Төсөлд судалгааны шинэ арга аргачлал болох соронзон болон радиометр (Mag+Rad)-ын	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									хэмжилтийг комплекс хэлбэрээр нийт 2393 тууш километрийн нислэгийн ажлыг гүйцэтгэж байна. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн судалгааны чиглэлээр Улсын төсвийн хөрөнгөөр 2021 оноос Өндөр технологийн түүхий эд-1 төслийг, 2022 оноос Өндөр технологийн түүхий эд-2 төслийг тус тус гүйцэтгэж байна. “1. ӨТТЭ-1-2021”, “ӨТТЭ-2-2022” төслүүдийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж, ажлыг эхлүүлсэн. 2. Төслүүдийн 2023 оны төсөл, төсвийг ЭБМЗ-ийн 2023.02.14, 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн УУХҮС-ын шийдвэрээр төсөл, төсвийн тодотголыг баталсан. 3. “ӨТТЭ-1-2021” төслийн ажлын үр дүнгийн тайлангийн явцад ҮГА-тай хамтран шуурхай хяналтыг хийсэн. “Геологийн судалгаа шинжилгээний төв”-ийн хэрэгжүүлж буй “Өндөр технологийн түүхий эд-1” төслөөр Хатуугийн голын илрэлийн хувьд ЗХ чиглэлтэй ГХЭ болон Nb, Zr-ны сулавтар хүдэржилт бүхий аляскит маягийн боржингын сунаж тогтсон 150-350 м өргөнтэй биет байх ба бидний судалгаагаар хамгийн өндөр утга нь ГХЭ-0,13%, Nb-0,05%, Zr-0,17%, Y-0,08%, дундаж утга нь ГХЭ-0,03%, Nb-0,01%, Zr-0,02%, Y-0,007%, байна. Харин	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									нарийвчилсан эрлийн Ихэрийн илрэлийн хувьд өргөрөгийн дагуу сунаж тогтсон 2-3 км хүртэл үргэлжлэх 2-3 ш дэл, судлын биет байх ба бидний шинжилгээгээр ГХЭ 0,03-1,3%, ихэнх дээжид Zr-0,5%-оос их, Nb 0,05-0,5% зэрэг агуулгатайгаар гадаргадаа илэрдэг. Эцсийн үр дүнгийн тайлангийн суурин боловсруулалтын ажил хийгдэж байна. “Демон инженеринг” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Өндөр технологийн түүхий эд-II” төслийн хээрийн судалгаагаар урьдчилсан байдлаар нарийвчилсан ажил гүйцэтгэж байгаа болон хэтийн төлөвтэй байж болох талбайнууд ялгаад байгаагаас дурдвал, ГХЭ агуулсан карбонатитын Хар Шарын даваа, моноцитын Хар бургаст, литийн хувьд Бага Элстэй, Элст уул, Мөнхтийн цагаан дөрвөлжин ордын ойр орших Мөнхтийн нуур, Онгонхайрханы дүүргийн Онгонит, Ве агуулсан пегматитуудын хэтийн төлөвт Цагаан могой талбай, W-Mo-Li эрдэсжилт бүхий Үйзэн, Ni-Co Түнтгэр хөх, Могой чулуут, Та-Nb-Li Урт Гозгор, бал чулууны хэтийн төлөвтэй талбай ЭШ-1 талбай орчим, Жаргалант зэрэг болно. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металлын эрэл үнэлгээний “ЭҮ-2-2021”, “ЭҮ-3-2021”, “ЭҮ-4-2022” болон Монгол орны алтны металлогени /1:500000-ны	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									масштаб/, өмнөд бүсийн алтны хэтийн төлөвийн судалгааны "Мета-алт-500" төслийг тус тус хэрэгжүүлж байна. Төслүүдийн 2023 оны төсөл төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 14, 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын тушаалаар баталсан. "ЭҮ-1-2020" төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Энэ төслийн ажлын үр дүнд 3 талбайн хэмжээнд алт, алт-мөнгө ба зэс, ховор металлын дан болон хам хүдэржилт бүхий 7 илрэлийг тогтоон хэтийн төлөвийг үнэлсэн байна. Монгол орны баруун, баруун өмнөд бүсийн алтны хэтийн төлөвийг тогтоох "БӨМ-Алт-2019" төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2023.04.11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Энэхүү ажлын үр дүнд өмнө тогтоогдсон шороон болон үндсэн ордуудыг судлан үнэлгээ өгсөнөөс гадна хэтийн төлөв бүхий 13 алтны хүдрийн талбайг ялган хэтийн төлвийн үнэлгээ өгсөн байна. Төслөөр баруун болон баруун өмнөд Монголын 557,9 мян.км² талбайд судалгаа хийж, хэтийн төлөв бүхий 9 бүсийн хэмжээнд 365,3 тн алтны баялгийг үнэлсэн байна. Төслийн үр дүнд баруун	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

								Монголд дарагдмал алтны шороон орд байх хэтийн төлөвтэй болохыг тогтоосон байна. Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ ба БНКаЗУ-ын хамтарсан “Хойд, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн V үе шат хэрэгжиж байна. /2021-2024 он/. Төсөлд хамтран оролцогч улсууд геологийн бүх төрлийн мэдээллийг нэгтгэж буй нь шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой ажил юм. Төслөөр Алтайн нурууны үргэлжлэл Говийн Алтайн уулсын хэмжээнд судалгааны ажил гүйцэтгэж, геологи болон холбогдох зургуудыг зохиосон. Мөн төслийн талбайн хэмжээнд 252 тодорхойлолт бүхий үнэмлэхүй насны санг бүрдүүлсэн байна. Төслийн ажлын үр дүнгийн тайлан болон хавсралт зургуудыг зохиосон. ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хийж байна.	
19			Мэдээллийн баяжуулалт хийж, үйлчилгээг цахимжуулах гео мэдээллийн нэгдсэн сангийн тоо	-	3	Батлагдсан: 2,079.10 Гүйцэтгэл: 2,003.61 Санхүүжилт: 1,623.4	Улсын төсөв	1.Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахимжуулах ажлын хүрээнд 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн “Геологийн баримт-1-2022” төслийн 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн. Төслийн 2023 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 2023.02.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан	70

									дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр баталсан. Төслөөр Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн санг Илрэл-3538, Худаг- 4575, Цооног-5217, Шлихийн хүрээ-2705, Өрөмдсөн цооног- 400, Эрдэсжсэн цэг-155 нийт 5880 ширхэг мэдээллээр баяжуулсан. Давхарга зүйн сан- 707, Горизонт-61, Интрузив чулуулгийн сан-3362, Эффузив чулуулгийн сан-360, Палеонтологийн олдворын дэд сан-3567, Үнэмлэхүй насны сан- 1119, 314 метадата оруулсан. Үүний үр дүнд нийт 9400 мэдээллээр нэгдсэн санг баяжуулсан. 2. Геологийн судалгааны ажлын үр дүнд цугларсан чулуун дээж болон Геологийн баримтын төв архивт цаасан байдлаар хадгалагдаж байгаа баримтыг цахимжуулах ажлын хүрээнд 2022 оноос хэрэгжүүлж эхэлсэн. “Цахим архив-1-2022”, “Чулуун дээжийн сан-1-2022” төслийн 2023 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2023 оны А/21 дүгээр тушаалаар баталж ажлыг эхлүүлсэн. Төслүүдийн 2023 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 2023.02.16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн гаргасан дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр баталсан. Төслийн хүрээнд ордын чулуун дээжийн мэдээлэл оруулах ажлын хүрээнд 250 ордын дээж	
--	--	--	--	--	--	--	--	--	---	--

									бүртгээд байна. Чулуун дээжийн фото зураг авах ажлын хүрээнд дээжийн-3243 фото зураг авч 2950 дээжийн зураг засварлаж бичвэр мэдээлэл оруулаад байна. Шлифийн 7544 ширхэг зураг ,аншлифийн 1301 ширхэг зураг, тайлангийн хавсралт материалаас 6166 лабораторийн үр дүнгийн хариуг сканер хийн оруулсан. Геологийн төрөл бүрийн тайлан цахимжуулах ажлын хүрээнд 519 тайлан, боть-1261 ширхэг буюу 144930 хуудас, 12378 ширхэг хавсралт зураг цахимжуулсан. Цахим архивыг баяжуулах ажлын хүрээнд еDOC архивын программд 608 тайлангийн 1006 хадгаламжийн нэгж, 743 ширхэг цаасан суурьт баримт цахимжуулсан. 1006 хадгаламжийн нэгжийг нүүр, гарчиг, агуулгын түвшинд хайх ОЛС-ийн программд холбоход бэлтгэн ашиглалтын хувь үүсгэсэн.	
Бүлэг 4.Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ногоон хөгжлийн бодлого										
Зорилго 4.1.Ногоон хөгжлийн сэргэлтийг эрчимжүүлэх хүрээнд байгалийн нөөц, баялгийг зүй зохистой ашиглаж, хүрээлэн байгаа орчны бохирдол, доройтлыг бууруулан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.										
20	4.1.2	МУХТЖҮЧ-6.3.2, ЗГҮАХ-5.1.11	Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх	Онги, Хэрлэн усан цогцолбор барих төслийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний хэрэгжилт, хувиар	-	100	905,000.0	Төр, хувийн хэвшлийн түншлэл	Усны нөөцийг хуримтлуулж ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх “Хөх морь” төслийн хүрээнд Онги-Орхон усан цогцолбор нь орхон голоос Онги голын урсацыг тэтгэх замаар Улаан нуурын усны түвшинг нэмэгдүүлж говийн бүсийн экосистемийн нөхцөлийг сайжруулах зорилготой бөгөөд Өмнөговь аймгаас 1.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт авч	30

									төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулаад байна. Мөн “Хэрлэн-Тоонот” усан цогцолбор нь Хэрлэн голын үерийн усыг хуримтлуулж хиймэл нуур үүсгэн олон жилийн дундаж урсцын 5-9 хувийг далд хоолойгоор дамжуулан Зүүн өмнөд говийн бүсийн хүн ам, уул уурхай, газар тариалан, мал аж ахуйн усны хэрэгцээг бүрэн хангах бөгөөд Оюу-Толгой ХХК-иас 3 сая.долларын хөрөнгө оруулалт авч ТЭЗҮ, БОННУ холбогдох бичиг баримтуудыг боловсруулахаар тендер зарлаад байна. (2023 оны 11 дүгээр сарын байдлаар хэрэгжилт өөрчлөгдөөгүй)	
21	4.1.3	МУХТЖҮЧ-6.2.4, ЗГҮАХ-5.1.8	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх	Нөхөн сэргээх талбайн хэмжээ, мянган га	-	2	40,000.0	Дотоодын хөрөнгө оруулалт	2023 оны уул уурхайн компаниудын ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан төлөвлөгөөнд техникийн нөхөн сэргээлтийг 1750.6 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 1527 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 140337.6 га талбайд нөхөн сэргээлт хийхээр, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд 1571.1 га талбайд 7.2 сая мод тарихаар төлөвлөсөн байна. Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6.3 дахь заалтын дагуу 2022 оны ашиглалтын үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайланг 2023 оны 2 дугаар сард ирүүлдэг. Одоогийн байдлаар ашиглалтын үйл ажиллагааны баталгаажсан тайлангаар техникийн нөхөн сэргээлтийг	90

									836.2 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 473.5 га талбайд, дүйцүүлэх хамгаалах ажлыг 18896.7 га талбайд хийсэн байна. Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1575.74 га талбайд 2753478 ширхэг мод тарьсан байна.	
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН										69.52

2023.12.28